

Би ингэж амьдарч байна.

Хөдөлмөрлөж байна.

Бойжиж байна..

Билэг авьяасныхаа хирээр

Шүлэг зохиож байна

Гүнигт амьдралын нүд рүү

Гутралгүй ширтэж байна.

Гэвч, түүний омо, сүрдэж

Гэлээ гэхэд, зам тавихгүй!

Амьдралтай би муудалцсан юм.

Аль ч талаараа тооцоотой юм.

Хэдий, тийм ч гэсэн түүнийг

Хэрэггүй гэж хэлэхгүй..

Харин ч,

Хамгийнхаа эцсээ хүртэл,

Хатан дэлхий дээр амьдрахдаа

Ширүүн гартай энэ амьдралыг

Шилдэг хайраар би хайрлана.

Шийдсэн хайраар би хайрлана!

Хүзүүгийг минь олсоор боомлоод,